

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 8 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид хуралдаж 4 тогтоол баталж, 2 асуудалд тэмдэглэлээр үүрэг өгөв. Шашны байгууллагад зөвшөөрөл олгох тухай, бичил уурхайн ашиглалтын талаар, сум хөгжүүлэх сангийн журмын хэрэгжилтийн тухай, малжуулах сангийн журам батлах тухай, Арвайхээр хотын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр батлах тухай, нэрэмжит болгох тухай, төрийн дээд шагналд уламжлах тухай асуудлуудыг тус тус хэлэлцэв.

Төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, газар тариалан, хууль сахиулах, батлан хамгаалах, биеийн тамир спорт, санхүү, авто тээвэр, авто зам, байгаль орчин, төрийн үйлчилгээний салбарт олон жил ажиллаж хариуцсан ажилдаа амжилт гарган аймаг орны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан 84 иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын одон медалиар шагналаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын ажлын албанаас Баруунбаян-Улаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Улс төрийн хэлмэгдэгч Ойдовын Жамъяангийн нөхөх олговрын наян сая төгрөгийг түүний төрсөн охин болох Есөнзүйл сумын иргэн Дуламсүрэнгийн Цэдэвт гардуулан өглөө.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Аймгийн удирдлагууд болон Засаг даргын Тамгын газрын хэлтэс, Засаг даргын дэргэдэх агентлаг, албадын дарга нарын ээлжит шуурхай хурлыг зохион байгууллаа. Тус хурлаар аймгийн Засаг даргын зүгээс зарим хэлтэс, агентлагийн дарга нар амралтаа дуусгаж ажилдаа орохыг үүрэг болголоо. Мөн орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудыг шуурхайлах, ажлын гүйцэтгэл, чанарт тавих хяналтыг нэмэгдүүлэх, хичээлийн шинэ жил эхлэх гэж байгаатай холбогдуулан сургууль, цэцэрлэгүүдийн бэлтгэл ажил, төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажилд сайтар анхаарахыг холбогдох байгууллагын удирдлагуудад үүрэг болгов.

Арвайхээр хотод баригдах Дулааны станцын зураг төслийг хийх компаниар шалгарсан БНСУ-ын "KDHEC" "KDHC", Монгол улсын "GIE" компанийн түншлэлийн инженерүүд дулааны станц, дулаан дамжуулах төв барих, дулаан дамжуулах шугам сүлжээ татах газар, трансиг газар дээр нь нягталж, шалгахаар аймагт ажиллалаа. Тус бүтээн байгуулалтын зураг, төслийг боловсруулж, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах үйл ажиллагаа 2020 оны 4 дүгээр сард дуусч, улмаар барилга угсралтын ажил хийгдэнэ.

"Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил"-болгон зарласантай холбогдуулан Арвайхээр хотод 21 цэгт автобусны буудал шинээр барьж эхлээд байна. Нийтийн тээврийг хөгжүүлж, иргэдээ хямд үнээр зорчих боломжийг бодлогоор дэмжиж 25 хүний суудалтай дунд оврын 4 ширхэг автобусыг худалдан авч үйлчилгээнд явахад бэлэн болоод байна. Мөн оршин суугчдын аюулгүй, амар тайван орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж Арвайхээр сумын 13 багт 120 ширхэг цамхагт гэрэл, төв гудамжинд 60 ширхэг гоёлын гэрэлт мод суурилуулаад байна.

Богд сум нь аймгийн төвөөс 200 км-ийн зайд байрладаг алслагдмал сумдын нэг юм. Тус сумыг байнгын, өндөр хурдны интернетэд холбох ажил эхэлж 30 км-т шилэн кабель татаад байна. Энэхүү ажил хийгдсэнээр албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх бүр өндөр хурдны интернетэд холбогдож мэдээ, мэдээллийг цаг алдалгүй авах боломж бүрдэх юм.

Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа айл, өрхийн амьдрах зориулалттай бүх байшин, орон сууцны сан хөмрөгийг тодорхойлох, орон сууцны фонд, хийц, ашиглалт, хүчин чадал, дэд бүтцийн хүртээмжийн талаар дэлгэрэнгүй мэдээллийн сан бүрдүүлэх зорилгоор байшин, орон сууцны улсын тооллого 8 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн зохион байгуулагдаж байна. Байшин, орон сууцны тооллогод аймгийн Засаг даргаар ахлуулсан аймгийн тооллогын комисс, 19 сум, 111 багийн Засаг даргаар ахлуулсан тооллогын комисс, түр товчоод ажиллаж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд 42 тоологч бэлтгэгдэн сум, орон нутагт ажиллаж байна

Аймаг дахь Политехникийн коллежийн оюутнууд "Оюутан цэрэг" сургалтад хамрагдаж цэргийн тангараг өргөлөө. Тангараг өргөх ёслолын арга хэмжээнд аймаг, орон нутгийн удирдлагууд, аймаг дахь Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн бие бүрэлдэхүүн, эцэг, эхийн төлөөлөл оролцсон байна.

Тайванийн Хүүхэд Гэр бүлийг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр аймгийн хэмжээнд зорилтот бүлгийн 500 хүүхдэд цүнх, хичээлийн хэрэглэл гардуулахаар болсон. Тус үйл ажиллагааны хүрээнд эхний ээлжинд Арвайхээр сумын 160 хүүхдэд хичээлийн хэрэглэлийг аймгийн удирдлагууд гардуулан өглөө.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв болон Японы хүүхдийн зүрх судасны нарийн мэргэжлийн эмч мэргэжилтнүүд 8 дугаар сарын 9, 10-ны өдрүүдэд аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвтөй хамтран хүүхдийн сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдээс үзлэгт хамрагдах зүрхний гажигтай хүүхдийн судалгааг авч, оношлигоонд хамруулах ажлыг зохион байгууллаа.

Бүрд суманд орчин үеийн стандартад нийцсэн тайз, дуу чимээ тусгаарлах акустик хавтан бүхий доторлогоотой хана, 250 хүний суудалтай үзвэрийн танхим, бүжгийн заал, номын сантай соёлын төвийн барилгыг улсын төсвийн 960 сая төгрөгийн хөрөнгөөр шинээр барьж ашиглалтад оруулж, иргэдийн ая тухтай орчинд соёлын үйлчилгээ авах боломжийг бүрдүүллээ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ

Улс, орон нутгийн төсвийн 43 байгууллагын төсвийн хэрэгжилт, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг ханган төлбөр тооцоог гүйцэтгэв. Энэ оны 8 дугаар сарын байдлаар 892 ш төлбөрийн хүсэлтээр 10.117.5 сая төгрөгийн гүйлгээг хийсэн байна.

Улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр 10.491.5 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 100% бүрэн орж ирсэнийг сарчилсан хуваарийн дагуу төсөвт байгууллагуудад хуваарилан санхүүжүүлэв.

Татвар төлөлт

Энэ оны 8 дугаар сарын байдлаар улсын төсөвт 2697.2 сая төгрөг, аймгийн төсөвт 5389.6 сая төгрөг, сумын төсөвт 2481.0 сая төгрөг, нийт 10567.8 сая төгрөг төвлөрүүлэн ажиллаж байна.

Татварын удирдлагын нэгдсэн систем хэрэгжиж нэхэмжлэхэд суурилсан төлбөрийн даалгаварын дагуу 108 нэхэмжлэхийн код олгоод байна.

Урд он болон тайлант оны өртэй 4 аж ахуйн нэгж байгууллагад мэдэгдэх хуудас гардуулан 1800.0 мянган төгрөгийн өрийг барагдууллаа.

Татварын Ерөнхий газрын даргын 2019 оны А/124 дүгээр тушаалаар баталсан "Татварын хяналт шалгалтанд хамруулах эрсдэл бүхий татвар төлөгчийн

жагсаалт"-ын дагуу татварын хяналт шалгалт хийх график гарган төлөвлөгөөт 5, төлөвлөгөөт бусаар 2 аж ахуйн нэгжийг шалгаж 25 аж ахуйн нэгжид зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

Нийгмийн даатгал

Энэ оны 8 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийгмийн даатгалын сангуудын орлого 1666.6 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 1633.2 сая төгрөг төвлөрүүлж сангийн төлөвлөгөө 98,1 хувийн биелэлттэй байна.

Өссөн дүнгээр аймгийн хэмжээнд нийт 2473 даатгуулагчдад тэтгэмжийн сангаас 1785.6 сая төгрөгийн тэтгэмж олгов. Үүнд: ХЧТА 968 даатгуулагчдад 95.4 сая төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмж-1006 даатгуулагчдад 1110.6 сая төгрөг, оршуулга 329 даатгуулагчдад 327.0 сая төгрөг, ажилгүйдлийн тэтгэмж 170 даатгуулагчдад 252.6 сая төгрөг тус тус олгосон.

Хэрэглэгчийг үнэлэх үнэлгээний төхөөрөмжөөр энэ сард 13 байцаагч 241 иргэд даатгуулагчаас үнэлгээ авсан. Үнэлгээгээр онц үнэлгээ 64, сайн үнэлгээ 12, дунд үнэлгээ 4, муу үнэлгээ 1 даатгуулагч үнэлгээ өгөөгүй 159 даатгуулагч байна.

Энэ сард нийгмийн даатгалын хэлтэс нь нийт 132 иргэний өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд 124 өргөдлийг шийдвэрлэж, хугацаа болоогүй 8 өргөдөл байна. Мөн архивын 276 лавлагаа гаргасан ба нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, төлөөгүй тодорхойлолт, цалингийн лавлагаа 240, ажилласан жил нөхөн тооцох 36 лавлагааг тус тус гаргасан байна.

ЭХМК-ын 4 удаагийн хурлаар нийт 136 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг хэлэлцсэн ба үүнээс шинээр 18, цуцалсан 13, сунгасан 105 хүний хөдөлгөөний мэдээллийн баазад орууллаа.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Монгол Улсын хууль 76, УИХ-ын тогтоол 54, Ерөнхийлөгчийн зарлиг 43, Засгийн газрын тогтоол 53, Үндсэн хуулийн цэцийн тогтоол 4, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, Олон улсын гэрээ 8, нийт 238 эрх зүйн актыг хууль зүйн лавлагаа мэдээллийн санд товъёогжуулан байршууллаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаарх танилцуулгыг нийт иргэдэд шуурхай хүргэх зорилгоор "Сургагч багш" бэлтгэх онлайн сургалтыг зохион байгуулж 19 сумын Засаг даргын Тамгын газрын дарга, төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн, багийн Засаг дарга болон нийгмийн ажилтан нийт 58 албан тушаалтныг хамрууллаа.

Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар 3 албан тушаалтны материалыг Авлигатай тэмцэх газарт хянуулж, дүгнэлт авлаа. Шинээр томилогдсон 4 албан тушаалтны хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан, баталгаажууллаа.

"Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай" төслийг шинэчлэн боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж баталлаа.

АРХИВЫН ТАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Аймгийн Архивын тасагт байгууллага, иргэдээс 1021 өргөдөл хүлээн авч 484 лавлагаа, 1756 хуулбар, 164 тодорхойлолт олгоод байна.

"Архивын тоо бүртгэл, эрэл хайлтын программ"-д 700 хадгаламжийн нэгжийн 58374 хуудас, 32030 заалт, 291625 хүний нэр, 291625 байгууллагын нэр, 48121 газар зүйн нэр бүхий захирамжлалын баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн.

Мөн 461 хадгаламжийн нэгжийн 49573 хуудас баримтыг PDF холбож, 610 хадгаламжийн нэгжийн 43300 хуудас баримтыг Photoshop программд засварлаж оруулсан байна.

Архивын тасагт нөхөн бүрдүүлэлтээр Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1992-2012 оны 201 хадгаламжийн нэгжийг, Эрүүл мэндийн газрын 1986-2010 оны 183 хадгаламжийн нэгжийг, Дэлхийн Зөн олон улсын байгууллагын орон нутгийн хөтөлбөр үйл ажиллагаа зогсож татан буугдсан тул 2002-2015 оны 392 хадгаламжын нэгжийг хүлээн авч, хадгаламжийн нэгжийг бүрдүүлэх эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийх талаар Сант сумын СӨББайгууллага, Арвайхээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажилтнуудад арга зүйн зөвлөлгөө өгч ажиллаа.

ЦАГДААГИЙН ГАЗАР:

Цагдаагийн газарт 2019 оны 08 дугаар сард 2931 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь 733 буюу +33.3 хувиар өссөн, үүнээс гэмт хэргийн шинжтэй 610, зөрчлийн шинжтэй 2321 гомдол мэдээлэл бүртгэгдсэн байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 556 буюу 91.2 хувийг 5 хоногт, 44 буюу 7,2 хувийг 6-аас дээш хоногт, зөрчлийн шинжтэй гомдлын 1935 буюу 83.4 хувийг 3 хоногт, 366 буюу 15.7 хувийг 4-өөс дээш хоногт шийдвэрлэсэн байна.

Гомдол мэдээллийн 39 нь буюу 1.3 хувийг шийдвэрлээгүй буюу хуулийн хугацаанд шалгаж байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны 08 дугаар сард 290 холбогдогчтой, 1.106.304.347 сая төгрөгийн хохиролтой 430 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 43 хэргээр буюу +11.1 хувиар өссөн, хэргийн илрүүлэлт 32.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс -8.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хэргийн төрлөөр: - Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг 11 бүртгэгдэж, 3 буюу +37.5 хувиар, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 23 бүртгэгдэж 14-өөр буюу +2.5 дахин, өмлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 227 бүртгэгдэж 56-аар буюу +32.7%, залилах гэмт хэрэг 17 бүртгэгдэж 4-өөр +28. хувиар, мал хулгайлах гэмт хэрэг 38 бүртгэгдэж 18 буюу +90.0 дахин, дээрэмдэх гэмт хэрэг 7 бүртгэгдэж 6-аар буюу +7.0 дахин, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 23 бүртгэгдэж 12-оор буюу +2.1 дахин тус тус өсч, хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 117 бүртгэгдэж 30-өөр буюу -20.4 хувиар буурсан, авто тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 16 бүртгэгдэж 14-оор буюу -41.7 %-иар буурч, тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 13 бүртгэгдэж 21-ээр буюу -61.7 хувиар тус тус буурсан байна.

Аймгийн хэмжээнд Өмчлөх эрхийн эсрэг 227 гэмт хэрэг бүртгэгдснээс иргэдийн өмчийг хулгайлах 125, малын хулгайлах гэмт хэрэг 38, тээврийн хэрэгсэл хулгайлах 13, дээрэмдэх 7, залилах 18 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 44 буюу +28.0 хувиар, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 23 бүртгэгдэж 12-оор буюу -41.2 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүд нь бүртгэгдсэн гэмт хэргийн дотор 66.1 хувийг эзэлж байна.

Өвөрхангай аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн 430 гэмт хэргээс 106 буюу 24.6 хувийг согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж байна. Зөрчил өмнөх оноос 20576 буюу +78.4 хувиар өссөн байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн, олон нийтийн эргүүл, байнгын пост, цагийн менежменттэй постуудыг ажиллуулснаар тодорхой үр дүнд хүрч байгаагаар тодорхойлогдож байна.

Нийт бүртгэгдсэн 46806 зөрчлөөс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 1345 зөрчил байгаа нь өмнөх оны мөн үеэс 168-аар буюу +14.2 хувиар өссөн байна.

ДӨРӨВ. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР

БОЛОВСРОЛ САЛБАР:

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын яам, Боловсрол телевиз хамтран хэрэгжүүлж буй “Би багш” реалити шоуны 2 дугаар шатны шалгаруулалтыг Арвайхээр суманд зохион байгуулж, шалгаруулалтад Баянхонгор, Төв, Өмнөговь, Дундговь, Өвөрхангай аймгаас шалгарсан бага ангийн 15 багш оролцлоо.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн сул орон тооны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, нийт 98 сул ажлын байранд 160 иргэн бүртгүүлж оролцсон байна. Сонгон шалгаруулалтад тэнцсэн үнэлгээ авсан багш нарын мэдээллийг ажлын байр зарласан сургууль, цэцэрлэгүүдэд хүргүүллээ.

Сургуулийн өмнөх, суурь, бүрэн дунд боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөрийг танилцуулах, багш нарын арга зүйн хөгжлийг дэмжих зорилгоор “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх арга зүй” сургалтыг зохион байгуулж, бүх судлагдахууны чиглэлээр ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нийт 1450 багш хамрагдсан байна.

2019-2020 оны хичээлийн жилийн аймгийн багш нарын бага хурлыг зохион байгуулж, 2018-2019 оны хичээлийн жилийн зорилтын хэрэгжилт, үр дүн, 2019 оны элсэлтийн ерөнхий шалгалт, улсын шалгалт, чанарын судалгааны шалгалт, Боловсрол, соёл, урлагийн газрын хөндлөнгийн үнэлгээний шалгалтын үр дүн, цаашид анхаарах асуудлууд, мөн судлагдахуун бүрээр шинэ хичээлийн жилд баримталж ажиллах чиглэл зэргийг танилцуулж, 2019-2020 оны хичээлийн жилийн зорилтыг хэлэлцэн баталлаа.

Аймгийн 5 сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал, 3 сумын цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын сул орон тооны сонгон шалгаруулалтыг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулллаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР:

“Уламжлалт анагаах ухааныг түгээн дэлгэрүүлэх нь” видео бичлэгийн уралдааныг цахим сүлжээгээр зохион байгуулж хамгийн их хандалт авсан 3 бичлэгийг байр эзлүүлж уламжлалт анагаах ухаан, эмчлэх арга зүйг иргэдэд сурталчиллаа.

Глобаль сангийн санхүүгийн дэмжлэгтэй Уянга, Нарийнтээл суманд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн ажиллагсадыг Сүрьеэ өвчний илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг газар дээр нь очиж зохион байгуулж, 421 хүнийг хамруулан, сүрьеэгийн 3 сэжигтэй тохиолдлыг илрүүлэн, 1 тохиолдол батлагдаж, эмчилгээ хийж хяналтанд аваад байна.

Аймгийн Эрүүл мэндийн газар, Уянсэтгэл, Түшигдөлгөөн өрхийн эрүүл мэндийн төв хамтран өрхийн эрүүл мэндийн төвийн харъяаны Хөгжлийн бэрхшээлтэй болон хэвтрийн 40 иргэнд уламжлалт анагаах ухааны эмчийн үзлэг, гэрийн сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлж, нэг удаагийн эмнэлгийн хэрэгслээр ханган ажиллалаа.

Жирэмсний “Нэрийн хяналт”-ын программын шинэчлэлт сайжруулалтыг хийж одоогийн байдлаар 4 өрх, 8 сумын эрүүл мэндийн төвийг шинэчлэлтийн программд оруулаад байна.

Сумын эрүүл мэндийн төвийн эмч, эх баригч, лаборант нарт БЗДХ-ын хам шинжийн оношилгоо эмчилгээ сэдэвт онол дадлага хослуулсан сургалт, иргэдэд

эхийн сүүгээр хооллолт, эхийн сүүний ач холбогдлын талаархи сургалтыг нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудад хийж гарын авлага, арга зүйгээр ханган ажиллалаа. Мөн 7 төрлийн мэдээлэл сурталчилгааны материал, шторкыг олон нийтийн мэдээ мэдээллийн 30 сүлжээ болон байгууллагын цахим хуудсаар 5 удаа, сурталчилж нийт 20000 гаруй хүнд мэдээллийг хүргэсэн.

Эрүүл мэндийн газар, Тайвань улсын оюутан эмч нартай хамтран эрүүл зан үйл төлөвшүүлэх 3 өдрийн сургалтыг зохион байгуулж, 36 өсвөр насны хүүхдүүдийг хамруулсан байна.

“Хепатитийг устгах ажилд хувь нэмэр оруулъя” уриан дор өдөрлөг зохион байгуулж, иргэдэд В.С вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааг хийн 4 төрлийн гарын авлагыг 2115 тарааж нийт 1897 хүнийг хамруулсан. 15-аас дээш насны иргэдийг хепатитийн В.С вирусийн халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд нийт 675 хүнийг хамруулсанаар нийт хепатитийн В вирус 34, С вирус 17 илрүүлсэн.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Сумдын ЗДТГ-тай хамтран 87 иргэдийг ЭМД-д хамруулж, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгаа үзүүлсэн.

Эрүүл мэндийн газар, “Эм гоо” эмийн сан хамтран эмийн зохистой хэрэглээ болон хепатитийн вирусийн эсрэг эмийн талаарх мэдээллийг нийт 400 орчимд хүнд хийж, зөвлөгөө өгч ажилласан байна.

“Хайртай аян”-ы хүрээнд иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл сурталчилгааг цахимаар болон орон нутгийн телевизээр тогтмол цацаж, 35 удаагийн мэдээллийг 29000 гаруй иргэдэд түгээж, байгууллагын болон орон нутгийн 12 цахим мэдээллийн хуудсаар 23 төрлийн мэдээллийг 9 удаа цацаж, 25000 гаруй иргэдэд мэдээлэл хүрсэн байна.

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

Аймгийн хэмжээнд байнгын 510, түр 141, улирлын 94 шинэ ажлын байр тус тус бий болсон байна. Нийт шинэ ажлын байрыг эдийн засгийн салбарын ангиллаар авч үзвэл хөдөө аж ахуйн салбар 15 хувь, боловсруулах үйлдвэрлэлд 32 хувь, бөөний худалдаа 7 хувь, боловсролын салбарт 10 хувь, уул уурхайд 1 хувь, барилга 8 хувь, бусад салбарт 26 хувь тус тус эзэлж байна. Шинэ ажлын байрыг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл 94 буюу 18 хувь нь төсвийн байгууллага, 416 буюу 82 хувь нь хувийн хэвшилд бий болсон байна. Ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагаас 489 ажлын байрны захиалга хүлээн авч 447 иргэнийг тохирох ажлын байранд зуучиллаа.

“Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд гарааны бизнесийг дэмжих “STARTUP WEEKEND” арга хэмжээг хамрагдаж шалгарсан 22 багт 220.000.000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас олголоо.

Солонгос хэлний түвшин тогтоох 16 дахь удаагийн шалгалтын бүртгэлийг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт зохион байгуулж нийт 60 иргэн бүртгүүлсэнээс 11 нь буюу 18 хувь нь эмэгтэйчүүд байна.

“Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т Арвайхээр сумаас хамрагдсан өрхийн 10 хүүхдэд хичээлийн хэрэгсэл, хувцас гардуулж, хөтөлбөрт хамрагдсан 50 хүүхдийг “Орхон” кино театрт үнэ, төлбөргүй кино үзүүллээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 2 удаагийн хуралдаан зохион байгуулж нийт 17 хүүхдийн асуудлыг хэлэлцэж, 1 хүүхдийн байнгын асаргааг цуцалж, 6 хүүхдийн асаргааг сунгаж, 10 хүүхдэд шинээр асаргаа тогтоолоо.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ:

“Залуучуудын манлайлал” үндэсний тавдугаар чуулганд залуучууд хөгжлийн төвийн мэргэжилтэн, 16 залуучуудын хамт оролцож санал бодлоо солилцлоо. Мөн аймгийн Залуучууд хөгжлийн төв нь “Залуусын хүч” нэг сарын аяныг эхлүүлээд 12 ажлыг төлөвлөөд ажиллаж байна.

Японы хүүхдийг ивээх сангаас Өвөрхангай аймгийн Арвайхээр, Уянга сумдад хэрэгжүүлж буй “Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төсөл, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар хамтран сургуулийн гадна байгаа 53 хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах, эрх нь зөрчигдөж, сургууль завсардсан болон хүчирхийлэл дарамтын улмаас завсардах эрсдэлтэй, байнгын асаргаа сувилгаа шаардлагатай тусгай хэрэгцээт хүүхдүүдийн нөхцөл байдлыг судлан, сэтгэлзүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ДЭД БҮТЦИЙН САЛБАР ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР:

Аймгийн газар тариалангийн голлох сумдад ургацын штаб байгуулан, ургац хураалтын бэлтгэл ажил үтрэм агуулахыг засварлах, ариутгах, техник засварыг шуурхайлах, богино хугацаанд ургацыг хураах, ургац хураалтын үед баримтлах технологийн ерөнхий зөвлөмж боловсруулж тариаланчидад хүргүүлж, малд идүүлэх, хулгайд алдах, хөлдөхөөс хамгаалах талаар арга зүйгээр хангаж ажиллаа.

Үр тарианы ургамлын ургац тогтоолтыг ажлын хэсгээс гадна үр тарианы аж ахуйн нэгж бүрийн төлөөллийг оролцуулж хийлээ. Үүнд: Улаан буудай 6860 га тариалалт хийсэнээс ургац авах боломжтой 6860 га талбайгаас урьдчилсан блансаар га-аас 14,5 цн буюу 9940 тн, ногоон тэжээл 976,5 га-гаас 1464 тн буюу га-гаас 15 цн, төмс 391 га-гаас 3910 тн буюу га-гаас 100 цн, хүнсний ногоо 232,1 га-гаас 2321 тн буюу га-гаас 100 цн ургац авах урьдчилсан төлөв гараад байна. 5 аж ахуй нэгжийн 14440м² үтрэм, 8800тн багтаамж бүхий 4 агуулах, 19 сумын 190 ширхэг 3725 тн-ны төмс хүнсний ногооны зоорийг засварлаж зоорийн ариутгалыг хийлгэж, арга зүйгээр хангалаа.

Швейцарийн хөгжлийн агентлагийн "*Ногоон алт, Малын эрүүл мэнд*" төслийн хүрээнд Уянга, Бат-Өлзий сумдын малзүйч мэргэжилтнүүдэд сүргийн эргэлтийн программын сургалт, тухайн сумын бэлчээрийн даацад тохируулан сум, бэлчээр ашиглалчдын хэсгийн сүргийн эргэлтийн тооцооллыг боловсруулах сургалтыг Хөдөө аж ахуйн их сургуультай хамтран зохион байгууллаа. Үүний үр дүнд тус сумдын малын сүргийн эргэлтийг 10 жилээр, сумын бэлчээр ашиглагчдын хэсэг тус бүрийн малын сүргийн эргэлийг 5 жилээр гаргаж малчдад мэдээлэл өгөн ажиллалаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Малыг ялган таних, бүртгэлжүүлэх”, “Цахим хөдөө аж ахуйн стратеги боловсруулах” төсөлд Уянга, Баянгол, Бат-Өлзий, Гучин-Ус сумдууд хамрагдахаар сонгогдсон. Энэ ажлын хүрээнд НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын суурин төлөөлөгч манай аймаг болон Уянга суманд ажиллаж удирдлагууд, мэргэжилтнүүдтэй уулзалт хийж, санал солилцсон.

Хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах ажлын төлөвлөөг боловсуурлан аймгийн Засаг даргын а/520 дугаар захирамжаар батлуулж сумдад хүргүүлэн ажиллаж байна.

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР:

Хархорин суманд “Мал эмнэлгийн чухал асуудлууд-2019” говийн бүсийн зөвлөгөөн 8 дугаар сарын 2-4 хооронд зохион байгуулагдаж, говийн бүсийн 6 аймгийн малын эмч, мэргэжилтнүүд, Швейцарын хөгжлийн агентлаг, АНУ-ын Хөдөө

аж ахуйн яам, Мерси Корпс, ЖАЙКА зэхэг олон улсын байгууллагаас нийт 300 гаруй хүн оролцлоо. Тус зөвлөгөөний үеэр мал эмнэлгийн хууль эрхзүйн шинэчлэлийн талаарх хийгдэж буй ажлууд болон Мал эмнэлгийн шат шатны байгууллагуудын хамтын ажиллагаа, цаашдын хөгжлийн талаар хэлэлцэж, зөвлөмж гаргалаа.

Жил бүр уламжлал болгон 7 дахь жилдээ зохиогдож байгаа аймгийн хэмжээний салбарын малын эмч нарын туршлага солилцох өдөрлөг Хархорин суманд боллоо. Уг арга хэмжээнд 19 сум, хувийн хэвшлийн Мал эмнэлэг, нэгжийн 43 эмч, аймгийн Мал эмнэлгийн газрын 11 эмч, мэрэгжилтнүүд сумдын Мал эмнэлгийн тасгийн 19 мэргэжилтэн нийт 73 хүн оролцлоо.

Сумдад мал угаалга болон бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины тарилгын ажил эхлэн явагдаж байгаа бөгөөд угаалгын ажил 1191804 толгой хамруулах төлөвлөгөөтэйгөөс 345956 толгой мал угааж 29 хувийн хамрагдалтай, бруцеллёзын вакцинжуулалтанд 1414083 толгой мал хамруулах төлөвлөгөөтэйгөөс 77830 толгой мал хамруулж, 5.3 хувийн гүйцэтгэлтэй явж байна.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР:

Төгрөг сумын цэцэрлэгийн өргөтгөл, Арвайхээр сумын "Төрийн банк", 30 айлын орон сууц, Арвайхээр сумын 6-р цэцэрлэгийн засвар, 108 дугаар байрны гадна фасадны засвар, спортын ордны гадна фасадны засвар, Гучин-Ус сумын цэцэрлэгийн засвар, Тамгын газрын засвар, Зүүнбаян-Улаан сумын ЗДТГазрын засвар, ЕБСургуулийн засвар, Баян-Өндөр сумын ЗДТГазрын засвар, цэцэрлэгийн засвар, 80 хүүхдийн дотуур байрны засвар, Бүрд сумын ЗДТГазрын засвар, Есөнзүйл сумын цэцэрлэгийн засвар, Өлзийт сумын цэцэрлэгийн засварын ажлуудад комисс ажиллуулж ашиглалтанд орууллаа.

Арвайхээр сумын 2-р цэцэрлэгийн өргөтгөл, Хүүхэд хамгааллын байр, 150 хүүхдийн цэцэрлэг, 108 дугаар байрны гадна фасадны засвар, 2-р цэцэрлэгийн засвар, гэр бүл хүний хөгжлийн төвийн засвар, Богд сумын цаг уурын барилга, Өлзийт сумын багийн төвийн барилга, Хархорин сумын Халаалтын зуух, өвсний фонд, Уянга сумын өвсний фонд, ЕБ-н 1-р сургуулийн гадна фасад болон спорт заалны дээврийн засвар, ЕБ-н 2-р сургуулийн гадна фасадны засвар, Нарийнтээл сумын халуун-усны барилга, Хужирт сумын ЕБ-ийн сургуулийн барилгын засварын ажлуудын гэрээ хийлээ.

Гучин-Ус сумаас Богд сум хүртэлх 100 км шилэн кабель угсрах, Хужирт сум ЗДТГазрын талбайн хойд талд 20 м цамхаг угсрах, Баянгол суманд 3,8 м бохир усны шугам угсрах, насос станцын барилга угсралт, тоног төхөөрөмж, цахилгаан хангамжийн угсралтыг хийх, үерийн ус зайлуулах далан сувгийг хийх, Тарагт сум дахь "Цагдаагийн газрын байнгын пост", Арвайхээр сум, 13-р баг, "150 хүүхдийн цэцэрлэг"-ийн барилгуудад ажил эхлүүлэх зөвшөөрөл олголоо.

Аймгийн 17 суманд баригдаж байгаа барилга угсралт, барилгын засвар, өргөтгөл хийгдаж байгаа 67 объектын ажилд 2-3 удаагийн техникийн хяналт хийж үүрэг даалгавар өгч ажиллааад байна.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Байгаль орчин ачлал жуулчлалын яамны Ойн бодлого зохицуулалтын газрын холбогдох албан тушаалтан Хархорин, Арвайхээр сумдын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж, газар дээр нь ирж ажиллалаа.

Есөнзүйл, Хайрхандулаан, Нарийнээл сумдын нутгаас идлэг шонхор амьдаар нь барих, тээвэрлэх үйл ажиллагаанд БОАЖГазар, Тагнуулын хэлтсийн хамтарсан ажлын хэсэг хяналт шалгалт хийж хяналт тавьж ажиллалаа.

УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР:

Энэ сард агаарын дундаж температур 15.8 – 22.5 градус дулаан, нийт нутгаар шөнөдөө 5-13 градус дулаан, өдөртөө 20-25 градус дулаан, ннэ сарын агаарын дундаж температурыг олон жилийн дундажтай харьцуулж үзвэл нийт сумдын нутгаар 0.7-1.8 градус дулаан байсан байна.

Богд, Хархорин, Бат-Өлзий, Уянга сумдын нийт нутаг болон Төгрөг, Баян-Өндөр сумдын баруун талаар ургамлын ургалт жигд сайн, Сант, Баянгол сумдын нутгаар ургамлын ургалт муу бусад сумдын нутгаар ургалтын байдал хэвийн зуншлагатай жилийнхэд хүрэхгүй дунд зэрэг байна.

СУМДЫН МЭДЭЭЛЭЛ

Хархорин суманд "Мал эмнэлгийн чухал асуудлууд-2019" говийн бүсийн зөвлөгөөн зохион байгуулагдаж, говийн бүсийн 6 аймгийн малын эмч, мэргэжилтнүүд, нийт 300 гаруй хүн оролцлоо. Мөн аймгийн малын эмч нарын туршлага солилцох өдөрлөг зохион байгуулагдаж 19 сум, хувийн хэвшлийн МЭҮНэгжийн 43 эмч, аймгийн Мал эмнэлгийн газрын 11 эмч, мэргэжилтнүүд сумдын Мал эмнэлгийн тасгийн 19 мэргэжилтэн нийт 73 хүн оролцлоо.

Зүүнбаян-Улаан, Нарийнтээл сумын нутгаас Идлэг шонхор шувууг соёлын зориулалтаар барих БОАЖЯ-ны зөвшөөрөлтөй Катар болон Кир улсын иргэдтэй тус сумдын удирдлагууд гэрээ байгуулж хяналт, тавин ажиллаж байна.

Монгол түмний бахархал, соёлын үнэт өв болсон адууны соёлыг дээдлэн дэлгэрүүлэх, адуу эдлэх уламжлалыг сэргээх зорилготой "Адуучин" тэмцээнийг Нарийнтээл суманд зохион байгууллаа. Тус тэмцээнд 40 иргэн оролцож 385 иргэн үзэж сонирхсон байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР